

# УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН 4-Р ЦЭЦЭРЛЭГ

Огноо: 2019.08.15

Увс аймгийн Улаангом сумын 4-р цэцэрлэгийн  
Хүүхдийн хоолонд шаардлагатай бүтээгдэхүүнийг нийлүүлэх  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын  
нэр:  
Гэрээний нэр:

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх

Төслийн дугаар:  
Харьцуулалт/  
гэрээний дугаар:

УВХХШБН-8/2019  
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ  
УВХХШБН-8/2019

## **ТЕНДЕРИЙН УРИЛГА**

Улаангом сумын 4-р цэцэрлэг нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Хүүхдийн хоол” нд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцаас бүрдэнэ.

- Үүнд
1. багц : Гурилан бүтээгдэхүүн
  2. багц : Хүнсний ногоо
  3. багц : Сүү, сүүн бүтээгдэхүүн
  4. багц : Мах махан бүтээгдэхүүн
  5. багц : Хуурай хүнсний бүтээгдэхүүн
  6. багц : Жимс жимсгэнэ витаминжуулалт

:

Үнийн саналыг 2019 оны 09 сарын 23-ны өдрийн 09<sup>00</sup> цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар хүлээн авна.

Үнийг саналыг нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 09 сарын 23-ны өдрийн 10 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээлэлийг доорх хаягаар авч болно.

[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж авна.

Оролцох хүсэлттэй компани иргэдийг урьж байна.

**Увс Улаангом сумын 4-р цэцэрлэгийн захиргаа**

**Утас 99459640, 95735366**

**А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

<b>1. Тендерийн цар хүрээ</b>	1.1.	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.
	1.2.	Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.
	1.3.	Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.
	1.4.	Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>	2.1.	Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.
<b>3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл</b>	3.1.	Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
	3.2.	Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
<b>4. Эрх бүхий тендерт оролцогч</b>	4.1.	Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.
	4.2.	Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
	4.2.1.	Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
	4.2.2.	Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
	4.2.3.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;
4.2.4.	Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;	

- 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендер оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендер оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендер туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3. Тендер оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендер оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

## 5. Эрх бүхий бараа

- 5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.
- 5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

## 6.

### Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

## 7. Тендерийн баримт бичгийн агуулга

- 7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:
- Тендер оролцогчид өгөх зааварчилгаа  
Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт  
Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт  
Тендер шалгаруулалтын маягт
- Тендерийн маягт
  - Үнийн хуваарь
  - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

---

Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. **Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.**

#### 8. Тендерийн баримт бичгийг тодруулах

8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө.

Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

#### 9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.

9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

---

### В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

#### 10. Тендер шалгаруулалт оролцо зардал

10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

#### 11. Тендерийн хэл

11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.

11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт

оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.

**12. Тендерийн иж бүрдэл**

- 12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТООЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн **тендерийн маягт болон үнийн хуваарь**;
  - (б) захиалагч шаардсан бол ТООЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх **тендерийн баталгаа**;
  - (в) тендерт оролцогчийг төлөөлж ТООЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн **гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл**;
  - (г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
  - (д) **тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд**;
  - (е) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь **тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт**;
  - (ё) ТШӨХ-д шаардсан ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.

**13. Тендерийн маягт болон үнийн хуваарь**

- 13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.
- 13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

**14. Хувилбарт тендер**

- 14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

**15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**

- 15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.
- 15.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
- 15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
- 15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.
- 15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан **Incoterms-ийн** хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.

- 15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТӨӨЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаас үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.
- 15.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:
- (а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:
1. **барааны EXW үнэ** (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;
  2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг **нэмэгдсэн өртгийн** болон бусад адилтгах албан татвар;
  3. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын **тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.**
- (б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:
1. ТШӨХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх **СИФ/СIF/ үнэ**, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх **СИП /СIP/ үнэ**;
  2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох **гаалийн, нэмэгдсэн өртгийн** болон бусад албан татвар;
  3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах **хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.**
- (в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:
1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
  2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
  3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;

4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
5. бараагТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:

Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож

- (1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;
- (2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна.

15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

15.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

15.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**16. Тендерийн валют**

16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

**17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**

17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

- (a) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
- (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
- (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.

**18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох**

18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- (a) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийн маягтаас тохирох маягыг ашиглан ирүүлнэ;



## баримт

- (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
  - (в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
  - (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
  - (д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
  - (е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
  - (ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
  - (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.
- 18.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
- (а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
  - (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
  - (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
  - (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
  - (д) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

## 19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардл

- 19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:
- (а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;
  - (б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон

агад  
нийцэж  
буйг  
нотлох  
баримт

бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;

- (в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;
- (г) захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.

Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

20. Тендер  
хүчинтэй  
байх  
хугацаа

20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

21. Тендер  
ирүүлэх  
хувь,  
тендер  
гарын  
үсэг  
зурах

21.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд "ЭХ ХУВЬ" гэсэн тодорхой бичиглэл хийнэ.

21.2. Тендерийг эх хувийг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

21.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

22. Тендерийг  
битүүмжлэх,  
бичиглэл  
хийх

22.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.

22.2. Тендерийн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТООЗ-ны 22.3, 22.4 –т заасныг баримтална.

22.3. Дугтуй нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр, хаяг, холбогдох утасны дугаартай байх;

(б) ТШӨХ-д заасан хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;

- (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д** тодорхойлсон **тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;**
- (г) ТООЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө **“НЭЭЖ ҮЛ БОЛНО”** гэж тэмдэглэгдсэн байх
- 22.4. Хэрэв дугтуйг 22.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 22.5. ТООЗ-ны 22.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.
- 23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 23.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 23.2. Захиалагч ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
- 24. Хугацаа хоцорсон тендер**
- 24.1. Захиалагч ТООЗ-ны 23 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг **“хугацаа хоцорсон”** гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
- 25. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 25.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
- 26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**
- 26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.
- 26.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 21 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт дугтуй дээр **“НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”,** эсхүл **“ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ”** гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.
- 26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 26.4. ТООЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.

---

#### **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

---

## 27. Тендерийг нээх

- 27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.
- 27.2. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.
- 27.3. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:
- (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
  - (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт .Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
  - (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх

## 28. Нууцлах

- 28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.
- 28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

## 29. Тендерийг тодруулах

- 29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ 30 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

**30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**

- 30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:
- (а) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
  - (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
  - (в) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
  - (г) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.
- 30.2. ТООЗ-ны 30.1 дэх заалтын (а) - (г)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 30.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:
- (а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
  - (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
  - (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.
- 30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

**31. Алдааг залруулах**

- 31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондүнг засварлах;
  - (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;
  - (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 31.2. Захиалагч, "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

- 32. Дотоодын давуу эрх**
- 32.1. ЗахиалагчТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.
- 33. Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 33.1. Захиалагч зөвхөн 30 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.
- 33.2. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 33.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.
- 33.3. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийг шалгаруулна.
- 33.4. Барааг ТООЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.
- 33.5. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэхь олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.
- 34. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 34.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 34.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 29 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн тодорхойлно. Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 34.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.
- 35. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх**
- 35.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

---

## **Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

---

- 36. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 36.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 36.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзана.
- 37. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**
- 37.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.
- 37.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 37.3. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.
- 38. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх**
- 38.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.
- 39. Гэрээнд гарын үсэг зурах**
- 39.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 39.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: <b>Увс Аймгийн Улаангом сумын 4-р цэцэрлэг</b>

ТӨӨЗ 1.1	тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Хүүхдийн хоолонд шаардагатай БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ УВХХШБН-8/2019
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1. багц : Гурилан бүтээгдэхүүн 2. багц : Хүнсний ногоо 3. багц : Сүү, сүүн бүтээгдэхүүн 4. багц : Мах махан бүтээгдэхүүн 5. багц : Хуурай хүнсний бүтээгдэхүүн 6. багц : Жимс жимсгэнэ витаминжуулалт
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөв</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Увс аймгийн Улаангом сумын 4-р цэцэрлэгийн байр 1 давхар аргазүйн өрөө</b>
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын <b>5 хоногоос багагүй байна.</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>



<p><b>ТӨӨЗ 12.1 (ё)</b></p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилд / 2018 он/ гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлэлтийн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, нотлох баримтууд /</li> <li>2. Гэрээний үүргээ биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ, тодорхойлолтыг заавал ирүүлэх.</li> <li>3. Байгууллагын ажилтны танилцуулга, удирдах ажилтан, хариуцсан менежерийн мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар</li> <li>4. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт авч ирүүлэх, /эх хувиар/</li> <li>5. Харъяа татварын хэлтэсийн тодорхойлолт ирүүлнэ /тодорхойлолт 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх, хуулбар хувь ирүүлэх бол хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлж болно/.</li> <li>6. Нийлүүлэх барааны баталгаат хугацааны мэдэгдэл гаргаж ирүүлэх.</li> <li>7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</li> <li>8. Тендерт оролцогч уг тендерийн багцад шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан барааг нийлүүлж гэрээний үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>9. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>10. Ажлын байрны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргаж ирүүлэх. ( )</li> <li>11. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар</li> <li>12. Хүнсний бүтээгдэхүүн агуулах байрны /зоорь/ гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2018 оны түрээсийн гэрээний хуулбар, зураг ирүүлэх,</li> <li>13. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх,</li> <li>14. Үйлдвэрийн хүчин чадал, багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт</li> <li>15. Улсын болон аймгийн мал эмнэлэгийн лаборторт махаа шинжлүүлсэн тухай шинжилгээний дүгнэлт болон гарал үүслийн гэрчилгээний хуулбар ирүүлэх</li> <li>16. Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтанд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан байх / хугацаа дуусаагүй /</li> <li>17. Орчны ариун цэврийн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах.</li> <li>18. Бүтээгдэхүүний жагсаалт ,бүтээгдэхүүн тус бүрийн орц, норм /Амталгааны зориулалтаар цэсэнд орсон бүтээгдэхүүнийг нэг хүүхдэд ногдох нормоор савлан амтлуулна. /</li> <li>19. Тухайн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлийн бичиг баримт, фото зураг тухайн оролцогчийн эзэмшигчийн нэр дээр байх</li> <li>20. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх.</li> <li>21. Бүтээгдэхүүний илчлэг/ ккал/ тооцож ирүүлэх</li> </ol> <p><b>Дээрх материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<p><b>ТӨӨЗ 14.1</b></p>	<p>Хувилбарт тендер ирүүлэхийг <b>“зөвшөөрөхгүй”</b>.</p>
<p><b>ТӨӨЗ 15.9</b></p>	<p>Бараа хүргэгдэх газар: <i>Увс Улаангом сумын 4-цэцэрлэг цэцэрлэг</i></p>
<p><b>ТӨӨЗ 15.10</b></p>	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>“тогтмол байна”</b></p>
<p><b>ТӨӨЗ 16.1</b></p>	<p>Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b></p>

ТӨӨЗ 18.1 (а)	<p>Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай”</p> <p><i>Тендерт оролцогч тухайн барааны үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ,</i></p> <p><i>Санал болгож буй барааны гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</i></p>
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>2018 оны тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан,</b>
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 2 жил тухайн бараатай ижил төстэй нийлүүлэлт хийж байсан талаар мэдээлэл ирүүлэх /ижил төстэй бараа нийлүүлж байсан талаархи гэрээний хуулбарыг ирүүлэх /МАЯГТ №: ТШМ-5Б дагуу ирүүлнэ.</b>
ТӨӨЗ 18.2 (в)	<p>Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b>Шаардлагатай:</b></p> <p><b>Үүнд:</b></p> <p>1.Тээврийн хэрэгсэл-1, Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын шаардлага хангасан байна.</p> <p>2.жин хэмжүүр-1, баталгаажсан байна.</p> <p>3.хөргөгч, хөлдөөгч-зориулалтын</p> <p>4.зоорь, агуулах –стандартын шаардлага хангасан байна.</p> <p><i>Эдгээрийн гэрчилгээний хуулбар, зураг зэргийг ирүүлж нотлоно.</i></p> <p><i>Агуулах байрны гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол <b>2018 оны түрээсийн гэрээг ирүүлэх.</b></i></p>
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцохгүй”</b>
ТӨӨЗ 19.1.(б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой): <b>1 жил</b>
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш <b>45</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>0 хувь</b>
<b>Г. Тендер ирүүлэх</b>	
ТӨӨЗ 23.3 (б)	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: <b>Улаангом сумын 4-р цэцэрлэг</b></p> <p>Байгууллагын хаяг: <b>Увс аймгийн Улаангом сумын 4-р цэцэрлэг</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>I давхар аргазүйн өрөө</b></p> <p>Аймаг, хот: <b>Увс Улаангом хот</b></p> <p>Шуудангийн дугаар: <b>Үгүй</b></p> <p>Улс: <b>“Монгол Улс” Увс аймаг</b></p>
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:
ТӨӨЗ 24.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2019 оны 09 дугаар сарын 23-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минутад</b></p>

<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>	
<b>ТӨӨЗ 28.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  Байшин, гудамжны нэр: <b>Увс аймаг Улаангом сумын 4-р цэцэрлэг</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>1 давхар аргагүйн өрөө</b>  Аймаг, хот: <b>Увс аймаг. Улаангом хот</b>  Шуудангийн дугаар: <b>Үгүй</b>  Улс: <b>“Монгол Улс”</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:  Огноо: <b>2019 оны 09 дугаар сарын 23-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>	
<b>ТӨӨЗ 40.1</b>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b>  Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b></p>
<b>ТӨӨЗ 42.1</b>	Гүйцэтгэлийн баталгаа:

## **БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Барааны тодорхойлолт:** Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлэгдэх бүтээгдэхүүн нь дараах 6 багцтай байна. Багц тус бүрийн бүтээгдэхүүнийг нэгжийн үнийн дүнгээр сонгоно.

1. багц : Гурилан бүтээгдэхүүн
2. багц : Хүнсний ногоо
3. багц : Сүү, сүүн бүтээгдэхүүн
4. багц : Мах махан бүтээгдэхүүн
5. багц : Хуурай хүнсний бүтээгдэхүүн
6. багц : Жимс жимсгэнэ витаминжуулалт

**1-р багцад тавигдах шаардлага:** Гурилан бүтээгдэхүүнд Боов боорцог, талх ,хэрчсэн гурил байх ба норм нормативаар өгөгдсөн илчлэг бүхий хэмжээгээр хүүхэд бүрт 80гр байна. 1 өдөрт хамрагдах хүүхдийн тоо 350-375

Бүтээгдэхүүнийг бэлтгэх явцад түүхий эдэд сахар орлуулагч зэрэг хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох зүйлсийг оруулахгүй.

Стандартын шаардлага хангасан сайн чанарын гурил, элсэн чихэр зөгийн бал зэрэг түүхий эдээр хийгдсэн байна. Мөн хүүдэд өгч болох, стандарт орц нормд тохирсон шинэ төрлийн боорцог, байж болно. Түүнийгээ холбогдох стандартын байгууллагаар шинжилгээ лабораторид хамруулж дүгнэлт гаргасан бичгийг авч ирэх.

**2-р багцад тавигдах шаардлага:** Хүнсний ногоо нь эх орны хөрсөнд ургаж тарьсан хүнсний өргөн хэрэглээний ногоо байвал зохих ба холбогдох хяналтын байгуулагад хамрагдсан шинжилгээний бичиг, дүгнэлтын бичигтэй байна. Мөн хадгалагдах зоорь савны байршил зургийн бас хавсаргана.

**3-р багцад тавигдах шаардлага:** Сүү, сүүн бүтээгдэхүүнд цэвэр сүү, аарц, тараг, хоормог зэрэг бүтээгдэхүүн байх ба чанарын шаардлагыг хангасан мэргэжлийн байгууллагын дүгнэлт бүхий бүтээгдэхүүнүүд байна.

Сүүнд тавигдах шаардлага: Сүү нь шаардлагатай шинжилгээнд хамрагдсан стандартын дагуу байна.

Аарцанд тавигдах шаардлага: Шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр монгол аргаар хийгдсэн

боз биш аарц байна.

Тараганд тавигдах шаардлага: Шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна.

Хоормогт тавигдах шаардлага: . Шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна.

**4-р багцад тавигдах шаардлага: Мах махан бүтээгдэхүүнд** хүүхдийн норм илчлэгт тохирсон биеийн өсөлтөт маш тохиромжтой 1-р зэргийн хонь, үхрийн мах байвал зохино.

Хонины маханд тавигдах шаардлага: Малын гарал угшилын бичиг малын эмчийн бичиг, шаарлагатай шинжилгээнд хамрагдсан байна.

Үхрийн маханд тавигдах шаардлага: Малын гарал угшилын бичиг малын эмчийн бичиг, шаарлагатай шинжилгээнд хамрагдсан байна. Мөн тээвэрлэх машин хадгадах зоорь савны байршил зургийн бас хавсаргана.

**5-р багцад тавигдах шаардлага: Хуурай хүнсний бүтээгдэхүүн** нь хүүхдийн хоолонд оролцох хэрэглээний сагсны төрлөөс сонгох ба тус бүтээгдэхүүний гаралын бичиг үйлдвэрлэсэн он сар өдөр, үйлдвэрлэсэн газар тодорхой байна. Мөн чанарын баталгаатай байх ба хадгалах хугацаа, болон одоо хадгалаж байгаа склад нь стандартын дагуу байх шаардлагатай.

**6-р багцад тавигдах шаардлага: Жимс жимсгэнэ:** Хүүхдийн эрүүл ахуй, шаардлагад тохирсон олон төрөлт жимс, жимсгэнэ жимсний шүүс нь амин дэмийн агууламж өндөртэй байх. Жимс жимсгэнэ болон шүүс нь зориулалтын саванд савлагдсан чанарын шаардлага хангасан холбогдох байгууллагын шинжилгээнд хамрагдсан бичигтэй байх шаардлагатай. Жимс тарьсан болон гадаадаас оруулж ирсэн гаралын бичиг он сар өдөр тодорхой байх.

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТ

**1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Бүтээгдэхүүнийг хүүхдийн тоогоор ажлын өдөр бүр хүлээн авах ба шаардлагатай тоогоор өглөө бүр захиална. Бүх нийтийн амралтын өдөр болон зайлшгүй шийдвэрээр цэцэрлэг амарсан хугацаанд захиалгыг хаана. Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг нийлүүлэгч хариуцах ба өдөр бүр захиалсан хэмжээгээр нярав хүлээн авна.

**2. Тавигдах бусад шаардлага, хяналт:** Бүтээгдэхүүний орц норм болон тендерийн шаардлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад захиалагчийн зүгээс хэсэгчилсэн болон бүрэн хяналт шалгалтыг хийж дүгнэлт хийж байна.

Бүтээгдэхүүн бүрийн хугацаа тодорхой, зориулалтын савалгаатай байна, үйлдвэрлэгчийн ажилтнуудын шинжилгээний бичиг хавсаргасан байна.

**Үйлдвэрлэлийн орчинд тавигдах шаардлага:** Үйлдвэрлэгч нь зориулалтын байр савтай байна.

Тоног төхөөрөмж нь зориулалтын, ариун цэвэрийн шаардлагыг хангасан байна.

**3. Баглаа, боодол:** Барааг захиалагч хүлээн авах хүртэл баглаа боодол стандартын шаардлага, эрүүл ахуйг хангасан байна.

**4. Бараа хүргэх газар :** Увс аймаг Улаангом сумын 4-р цэцэрлэгийн байр

№	Барааны нэр, тодорхойлолт	Ажлын нэг өдөрт /Тоо, хэмжээ/	<sup>1</sup> Нийлүүлэх хуваарь 9,10,11,12 сард_5_ <sup>2</sup> хойш /, долоо хоног, <u>сараар/</u>
1	Гурилан бүтээгдэхүүн	Ажлын өдрөөр	Манай цэцэрлэг нь 9 бүлэгт 375 хүүхэдийг хүлээн авч ажилладаг.
2	Жимс жимсгэнэ, Хүнсний ногоо	Ажлын өдрөөр	

3	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Ажлын өдрөөр	
4	Мах махан бүтээгдэхүүн	Ажлын өдрөөр	
5	Хуурай хүнсний бүтээгдэхүүн	Ажлын өдрөөр	
Тайлбар : Бүтээгдэхүүнийг тухайн өдрийн цэсний дагуу захиална			



**2019 оны 02- сараас 05 сарын багцийн дүнгийн Нийт худалдан авалтын сар 4 сар /Хавар/**

1. багц : Гурилан бүтээгдэхүүн	8,000,000
2. багц Хүнсний ногоо	5,000,000
3. багц : Сүү, сүүн бүтээгдэхүүн	9,000,000
4. багц : Мах махан бүтээгдэхүүн	13,000,000
5. багц : Хуурай хүнсний бүтээгдэхүүн	10,000,000
6. багц : Жимс жимсгэнэ витаминжуулалт	4,000,000
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ	49,000,000

**2019 оны 09-12 сарын багцийн дүн. Нийт худалдан авалтын сар 4 сар /Намар/**

1. багц : Гурилан бүтээгдэхүүн	11,000,000
2. багц Хүнсний ногоо	5,000,000
3. багц : Сүү, сүүн бүтээгдэхүүн	13,000,000
4. багц : Мах махан бүтээгдэхүүн	20,000,000
5. багц : Хуурай хүнсний бүтээгдэхүүн	12,000,000
6. багц : Жимс жимсгэнэ витаминжуулалт	5,995,000
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ	66,995,000

**ЖИЛИЙН НИЙТ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ТӨСӨВТ ӨРТӨГ 115.995.000**

